



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 6 сарын 14 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

「Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх」
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 39 дүгээр зүйлийн 39.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.5.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-ийн хавсралтад дурдсан нэр бүхий 29 иргэний даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Тогтоол батлагдсантай холбогдуулан даатгалын гэрээ, баталгааны үлдэгдлийн тооцоог хийж, ажлын 10 хоногийн дотор Хороонд мэдэгдэхийг “Миг даатгал” ХХК /Б.Мөнххишиг/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН